



# МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ 2022



# АГУУЛГА

---

**01** ҮНДЭСЛЭЛ

**02** ТОДОРХОЙЛОЛТ БА ХАМРАХ ХҮРЭЭ

**03** МАНАЙ ҮНЭЛГЭЭ

**04** ХАВСРАЛТ

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

---

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БОНЗ	Байгаль орчин, нийгэм ба засаглал
МИК	Монголын Ипотекийн Корпораци
ОССК	Орон сууцны санхүүжилтийн компани
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилт
ТБНББСЗ	Тогтвортой Байдлын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөл
ТоС Холбоо	Тогтвортой Санхүүгийн Холбоо
ТОУС	Тайлагналын Олон Улсын Санаачилга
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



# ҮНДЭСЛЭЛ

---

2022 онд “МИК Холдинг” ХК-ийн охин компани “МИК ОССК” ХХК нь үйл ажиллагаандаа материаллаг байдлын үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Материаллаг байдлын үнэлгээ нь компанийн бизнесийн үйл ажиллагаа болон оролцогч талуудад нөлөөлж болзошгүй байгаль орчин, нийгэм, засаглалын олон асуудлуудыг тодорхойлох, үнэлэх үйл явц бөгөөд тэдгээрийг компанийн стратеги, зорилтууд болон бизнесийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх, тайлагнах сэдвүүдийн товч жагсаалт болгох үйл явц юм. Ингэснээр бид тогтвортой үйл ажиллагаа, хариуцлагатай бизнес эрхлэх зарчимтай нийцэж буй хүчин чармайлтаа урьтал болгохыг эрхэмлэж байна.

Материаллаг байдлын концепт ба холбогдох эрдэм шинжилгээний судалгааны гол дүгнэлтүүдээс дурдахад:

- Материаллаг сэдвийг тодорхойлох үйл явцыг ил тод мэдээлэхгүй байх нь тогтвортой байдлын тайлангийн хүлээн зөвшөөрөгдсөн, найдвартай байдлыг бууруулдаг.
- Материаллаг сэдвийг тодорхойлох үйл явц дутмаг байх нь тогтвортой байдлын гүйцэтгэлийг бүрэн бус, хангалтгүй болгодог.
- Тогтвортой хөгжлийн материаллаг асуудлуудыг тодорхойлж, ил тод болгох нь дунд болон урт хугацаанд санхүүгийн гүйцэтгэлийг сайжруулдаг.

Дэлхийн хамгийн том (орлогоор) 250 компанийн 80 орчим хувь нь тайландаа тогтвортой байдлын материаллаг асуудлуудыг тодорхойлсон байдаг ч 41 хувь нь үнэлгээний үйл явцаа тайлбарлаагүй, талаас их хувь нь (55 хувь) оролцогч талуудын санал хэрхэн туссаныг нийтэд мэдээлдэггүй байна.

---

Эх сурвалж: ТОУС, Кэй Пи Эм Жи

# ҮНЭЛГЭЭНИЙ ҮЙЛ ЯВЦ

МИК нь компанийн материаллаг байдлыг үнэлэхдээ Кэй Пи Эм Жи\*-ийн материаллаг байдлын үнэлгээний удирдамжид суурилсан бөгөөд уг удирдамжид тодорхойлсон алхмуудын дагуу үнэлгээг гүйцэтгэсэн.



KPMG International Sustainable Insight. (n.d.). <https://assets.kpmg.com/content/dam/kpmg/pdf/2014/10/materiality-assessment.pdf>

## ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ

Материаллаг байдлын үнэлгээний зорилго нь манай компани болон оролцогч талуудад хамааралтай БОНЗ, тогтвортой байдлын хамгийн чухал асуудлуудыг тодорхойлж, эрэмбэлж, эдгээр асуудлуудын бизнес болон оролцогч талуудад үзүүлж болзошгүй нөлөөллийг илүү сайн ойлгож, өндөр ач холбогдолтой асуудлуудыг шийдвэрлэхэд нөөц, хүчин чармайлтаа төвлөрүүлэхийг анхаарахад оршино. Мөн эдгээр асуудлыг тодорхойлсноор цаашид компанийн БОНЗ-ын гүйцэтгэл ба тайлагналыг сайжруулах, эрсдэлийг удирдах, оролцогч талуудын хүлээлтийг хангахад түлхэц болох зэрэг ач холбогдолтой. Бид материаллаг байдлыг дараах байдлаар тодорхойлсон:

*"Материаллаг байдал нь манай бизнес болон оролцогч талуудад хамгийн өндөр хамааралтай БОНЗ-ын асуудлууд байхаас гадна анхаарал хандуулаагүйн улмаас богино, дунд эсвэл урт хугацаанд бидний үнэ цэн бүтээх чадвар болон өрсөлдөх чадвараа хадгалахад нөлөөлж болзошгүй асуудлууд багтсан байна."*

### Зарим эх сурвалжийн Материаллаг байдлын тодорхойлолт

KPMG	Materiality is the principle of defining the social and environmental topics that matter most to your business and your stakeholders.	Материаллаг байдал нь таны бизнес болон оролцогч талуудад хамгийн их хамааралтай нийгэм, байгаль орчны сэдвүүдийг тодорхойлох зарчим юм.
Deloitte	Materiality is about identifying and addressing what matters most to you and to your most important stakeholders; what you have the most impact on; and what impacts you the most. In other words, 'materiality' means 'priority'.	Материаллаг байдал нь танай байгууллага болон танай хамгийн чухал оролцогч талуудад хамгийн чухал, танай байгууллагын хамгийн их нөлөөлдөг болон танайд хамгийн их нөлөөлдөг асуудлуудыг тодорхойлох явдал юм. Өөрөөр хэлбэл, "материаллаг" гэдэг нь "нэн тэргүүнд тавигдах" гэсэн утгатай.
GRI	The GRI's 2021 Sustainability Reporting Standards suggest that a sustainability topic is material when it represents the organization's most significant impacts on the economy, environment, and the people, including impacts on their human rights.	GRI-ийн 2021 оны Тогтвортой байдлын тайлангийн стандартад тогтвортой байдлын сэдэв нь тухайн байгууллагын эдийн засаг, байгаль орчин, хүмүүст үзүүлэх хамгийн чухал нөлөөлөл, түүний дотор хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг илэрхийлж байвал чухал гэж үздэг.

Материаллаг байдлыг үнэлэхдээ *Double Materiality* буюу Давхар материаллаг байдлын ойлголтыг тусгасан. Давхар материаллаг байдал нь компаниуд зөвхөн байгаль орчин, нийгэмд нөлөөлөл үзүүлээд зогсохгүй гадаад орчин, нийгмийн хүчин зүйлийн нөлөөнд мөн автдаг талаар тайлбарладаг. Энэхүү ойлголтын тусламжтайгаар бид компанийн тогтвортой байдлын гүйцэтгэл, болзошгүй эрсдэл, боломжуудын талаар илүү өргөн хүрээтэй, цогц ойлголттой болсон.

**Уур амьсгалын өөрчлөлт, БОНЗ-той  
холбоотой байгууллагын үнэ цэнд үзүүлэх  
нөлөө**



Guidelines on Non-financial Reporting: Supplement on Reporting Climate-related Information published in June 2019, European Commission

## МАТЕРИАЛЛАГ СЭДВҮҮДИЙГ ТОДОРХОЙЛОХ

Материаллаг сэдвүүдийг тодорхойлохдоо бид холбогдох дотоод, гадаад эх сурвалжуудыг ашигласан. Гаднын эх сурвалжийн хувьд БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж, хамрах хүрээ, стандартууд, салбарын зураглал, Мүүдис БОНЗ-ын үнэлгээ болон бусад жишиг байгууллагын тайлангуудыг эх сурвалж болгов. Дотоод эх сурвалжийн хувьд өмнөх жилүүдийн тайлан, стратеги төлөвлөгөө, компанийн процессын зураглал, болон манай үйл ажиллагааны талаар оролцогч талуудын төлөөллүүдтэй хийсэн ярилцлага, санал бодол бүхий сонин хэвлэлүүдийг ашигласан. Эдгээр эх сурвалжийн тусламжтайгаар бид 47 дэд сэдвийг тодорхойлсон бөгөөд дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү.

### Гадаад эх сурвалж:

- БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын удирдамж 2022
- Олон улсын тайлагналын стандарт, хамрах хүрээ
  - ТБНББСЗ Тогтвортой хөгжлийн материаллаг байдлын зураглал
  - ТОУС
- Мүүдис БОНЗ-ын үнэлгээ
- Жишиг байгууллагын БОНЗ, тогтвортой байдлын тайлан

### Дотоод эх сурвалж:

- Компанийн өмнөх жилүүдийн Жилийн тайлан
- МИК Групп компанийн 2022-2026 оны Стратеги төлөвлөгөө
- Компанийн процессын зураглал
- Сонин хэвлэл
  - Форбес 15 Тусгай дугаар /оролцогч талуудын төлөөллүүдтэй хийсэн ярилцлага/



## БҮЛЭГЛЭХ

Үнэлгээний явцад тодорхойлсон 47 дэд сэдвийн жагсаалтыг бид 15 үндсэн сэдэвт бүлэглэсэн бөгөөд цагаан толгойн үсгийн дарааллаар доор харуулав.

Байгаль орчин	Нийгэм	Засаглал
Байгаль орчны ул мөр	Бүтээгдэхүүний хүртээмжтэй болон худалдан авах чадварт нийцсэн байдал	Бизнесийн ёс зүй
Уур амьсгалын өөрчлөлт	Оролцогч талуудын оролцоог хангах механизм	Ил тод байдал
	Санхүүгийн мэдлэг, боловсрол	Комплаенс
	Хүмүүн капиталын хөгжил	Улс төрийн тогтвортой байдал
	Хүн ам зүй, нийгмийн чиг хандлага	Хувийн мэдээллийн нууцлал ба өгөгдлийн хамгаалалт
	Эдийн засгийн хувь нэмэр	Эрсдэлийн удирдлага
	Эрх тэгш боломж	

# СЭДВҮҮДИЙН НӨЛӨӨЛӨЛ, АЧ ХОЛБОГДЛЫГ ҮНЭЛЭХ

Сэдвүүдийн ач холбогдлыг үнэлэхдээ дараах 4 шалгуур үзүүлэлтэд үндэслэн оноо өгөх аргачлалаар үнэлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг материаллаг байдлын матрицад нэгтгэсэн. Давхар материаллаг байдлын концептын дагуу (i) *Inward impact* буюу гадаад орчноос МИК-ийн үнэ цэнд нөлөөлөх БОНЗ-ын асуудлууд; (ii) *outward impact* буюу Компани нь бизнесийн үйл ажиллагаа эсвэл ханган нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдал гэх дотоод, гадаад нөлөөлөх байдлыг үнэлж, үр дүнг нэгтгэв.



Компани нь бизнесийн үйл ажиллагаа эсвэл ханган нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлөх байдал

## Үнэлсэн шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур	Тодорхойлолт	Оноо
Хамрах хүрээ	БОНЗ-ын асуудлын байгаль орчин, нийгэм, оролцогч талуудад үзүүлэх нөлөөллийн цар хүрээ.	1-4
Ноцтой байдал	БОНЗ-ын асуудлын байгаль орчин, нийгэм, оролцогч талуудад үзүүлэх нөлөөллийн ноцтой байдал.	1-4
Давтамж	БОНЗ-ын асуудал үүсэх эсвэл ирээдүйд давтамж нэмэгдэх магадлал.	1-4
МИК-ийн нөлөөлж буй байдал	Бизнесийн үйл ажиллагаа эсвэл ханган нийлүүлэлтийн сүлжээгээр дамжуулан компани нь БОНЗ-ын асуудалд нөлөөлөх, хянах чадвар.	1-4

The double-materiality concept - global reporting initiative. (n.d.). Retrieved December 19, 2022, from <https://www.globalreporting.org/media/jrbntbyv/griwhitepaper-publications.pdf>

## ЭРЭМБЛЭХ

### Outward impact үнэлгээний үр дүн.

- Эдийн засгийн хувь нэмэр
- Бүтээгдэхүүний хүртээмжтэй болон худалдан авах чадварт нийцсэн байдал

- Уур амьсаглын өөрчлөлт
- Бизнесийн ёс зүй
- Санхүүгийн мэдлэг, боловсрол
- Хувийн мэдээллийн нууцлал ба өгөгдлийн хамгаалалт
- Байгаль орчны ул мөр

- Эрсдэлийн удирдлага
- Улс төрийн тогтвортой байдал
- Оролцогч талуудын оролцоог хангах механизм

- Ил тод байдал
- Компаенс
- Хүмүүн капиталын хөгжил
- Эрх тэгш боломж

- Хүн ам зүй, нийгмийн чиг хандлага

бага

өндөр

## ЭРЭМБЛЭХ


### Inward impact үнэлгээний үр дүн.

- Улс төрийн тогтвортой байдал
- Эдийн засгийн хувь нэмэр
- Бизнесийн ёс зүй
- Санхүүгийн мэдлэг, боловсрол
- Оролцогч талуудын оролцоог хангах механизм
- Компаенс
- Бүтээгдэхүүний хүртээмжтэй болон худалдан авах чадварт нийцсэн байдал
- Хувийн мэдээллийн нууцлал ба өгөгдлийн хамгаалалт
- Эрсдэлийн удирдлага
- Уур амьсаглын өөрчлөлт
- Байгаль орчны ул мөр
- Ил тод байдал
- Хүн ам зүй, нийгмийн чиг хандлага
- Хүмүүн капиталын хөгжил
- Эрх тэгш боломж

бага

өндөр

# МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН МАТРИЦ



- Байгаль орчин
- Нийгэм
- Засаглал

- Хамрах хүрээ /оролцогч талууд+олон нийт/
- Хамрах хүрээ /нийт оролцогч талууд/
- Хамрах хүрээ /дотоод оролцогч талууд/

# ТЭРГҮҮЛЭГЧ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛГУУД

Үнэлгээний үр дүнд материаллаг асуудлуудад холбогдох тогтвортой хөгжлийн нэн тэргүүний зорилгуудыг тодорхойллоо. Ингэснээр бид тогтвортой санхүүжилтийн чиглэлд баримтлах бодлого стратегийг нэн тэргүүний хамааралтай ТХЗ-уудтай уялдуулж, байгаль орчин, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллийг таних, хэмжих, мөн цаашид сөрөг ул мөрийг багасгахад түлхэц болох юм.

## Нэн тэргүүний Тогтвортой Хөгжлийн Зорилгууд



- Орон сууцны өмчлөлийг дэмжиж, Монгол Улсад хүртээмжтэй, өсөн хөгжиж буй, тогтвортой орон сууцны зах зээлийг дэмждэг.
- Орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх, орон сууцанд шилжин амьдрахыг дэмжсэнээр хотжилтыг дэмждэг.
- Ипотекийн зээлийн эргэн төлөлтөөр шинэ зээлийг санхүүжүүлэх схемийг бий болгосноор хөтөлбөрийн тогтвортой санхүүжилтийг хангадаг.



- Банк санхүүгийн салбарт хөрвөх чадварыг нэмэгдүүлдэг.
- Ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлж, үржүүлэгч нөлөөгөөр барилга, үл хөдлөх хөрөнгийн салбарын ажил эрхлэлт, бүтээн байгуулалт, материал, үйлчилгээний нэмэлт эрэлтийг бий болгох замаар эдийн засгийн өсөлтийг дэмждэг.
- Айл өрхүүдэд бүтээмжийн цагийг нэмэгдүүлж, эдийн засгийн боломжийг сайжруулдаг.

## Хоёрдогч Тогтвортой Хөгжлийн Зорилгууд



- Хүн-төр-хувийн хэвшлийн түншлэлээр дамжуулан тогтвортой, тэсвэртэй хот байгуулалтыг дэмждэг.



- Орон сууцжуулах бодлого нь өрхүүдийн уур амьсгалтай холбоотой гамшиг, цаг агаарын эрс тэс нөхцөлд дасан зохицох, тэсвэрлэх чадварыг нэмэгдүүлж, эмзэг байдлыг бууруулдаг.
- Хотжилтыг дэмжих замаар уур амьсгалын зорилтуудад хувь нэмрээ оруулж, агаар, усны бохирдлыг бууруулах боломжтой.

Бид үндсэн үйл ажиллагаагаараа дамжуулан хот төлөвлөлтийг сайжруулах, ядуурал, нийгмийн тэгш бус байдлыг бууруулах, нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, орон сууцны тэгш, тогтвортой зах зээлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх зэргээр олон нийт, нийгэм эдийн засагт системийн эерэг нөлөө үзүүлдэг бөгөөд ТХЗ-ын 12-т нь шууд болон шууд бусаар нөлөө үзүүлдэг. Манай ТХЗ-ын дэлгэрэнгүй тайлантай [ЭНД](#) дарж танилцана уу.

## ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН САНАЛ

Бид үнэлгээний үр дүнг сайжруулах зорилгоор оролцогч талуудаас судалгаа авах замаар тэдний оролцоог хангаж ажиллалаа. Судалгаанд дотоод гадаад 41 оролцогч талууд оролцож, холбогдох БОНЗ-ын сэдвүүдийг МИК-ийн бизнесийн үйл ажиллагаанаас үүдэлтэй болон үйл ажиллагаанд ач холбогдолтой байдлаар эрэмбэлж, мөн нэмэлт саналуудыг хүргүүлсэн. Оролцогч талуудын төлөөлөлд зохицуулагч байгууллага, харилцагч банк/ББСБ, хэрэглэгч/зээлдэгч, нийлүүлэгч, хэвлэл мэдээлэл, ToC холбоо, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч болон ажиллагсад удирдлагын багаас бүрдсэн төлөөллүүд багтсан. Судалгааны үр дүнд хамгийн ач холбогдолтой гэх 5 хариултыг оруулав.

*МИК-ийн үйл ажиллагаанаас үүдэлтэй эдийн засаг, байгаль орчин, нийгэмд нөлөөлөх асуудлуудыг ач холбогдлоор эрэмбэлсэн судалгааны үр дүн:  
/Outward impact буюу МИК-ийн гадаад орчинд үзүүлэх нөлөө/*



*Байгаль орчин, нийгэмтэй холбоотой асуудлуудыг МИК-д үзүүлэх нөлөөллөөр эрэмбэлсэн судалгааны үр дүн:  
/Inward impact буюу гадаад орчноос МИК-д үзүүлэх нөлөө/*



*МИК-ийн хувьд засаглалын асуудлуудыг\* ач холбогдлоор эрэмбэлсэн судалгааны үр дүн:*



\*Судалгааны үр дүнг харвал манай 4 шалгуур үзүүлэлтээр үнэлсэн үнэлгээний үр дүнтэй нийцэж байна. Харин нэмэлт саналын дагуу Corporate governance сэдэвт бусад засаглалын асуудлууд багтсан гэж үзсэн тул хассан. Мөн улс төрийн тогтвортой байдал, шийдвэр гаргалттай холбоотой асуудлыг өндөр хамааралтай гэж үзэж нэмж тодорхойлсон болно.

# ХАВСРАЛТ 1

## БАЙГАЛЬ ОРЧИН

Сэдэв	Тодорхойлолт	Дэд сэдэв
<p>Байгаль орчны ул мөр /Environmental footprint/</p>	<p>Энэ сэдэв нь манай бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчинд үзүүлж буй ул мөр, нөлөөллийн тухай байна. Үүнд нүүрсхүчлийн хийн ялгарал, усны хэрэглээ, эрчим хүч, хог хаягдал зэрэг сэдвүүд орно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрчим хүч</li> <li>• ХХЯ ялгаруулалт</li> <li>• Ус</li> <li>• Хог хаягдал</li> <li>• Биологийн олон янзын байдал</li> <li>• Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/</li> </ul>
<p>Уур амьсгалын өөрчлөлт /Climate change/</p>	<p>Энэ сэдэв нь манай байгууллагын уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлд баримталж буй бодлого, санаачилгын тухай байна. Уур амьсгалын эрсдэлд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй биет болон шилжилтийн эрсдэлүүд байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Уур амьсгалын бодлого</li> <li>• Уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ</li> <li>• Уур амьсгалын хөрөнгө оруулалт</li> </ul>



# НИЙГЭМ

Сэдэв	Тодорхойлолт	Дэд сэдэв
<p>Бүтээгдэхүүний хүртээмжтэй болон худалдан авах чадварт нийцсэн байдал /Access and affordability/</p>	<p>Энэ сэдэв нь манай санхүүгийн бүтээгдэхүүн нь зах зээл ба/эсвэл хүн амын зорилтот бүлгүүдэд хэр хүртээмжтэй болон тэдний худалдан авах чадамжид хэр нийцтэй тухай байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Зорилтот бүлэг</li> <li>• Өрхийн орлогын түвшин</li> </ul>
<p>Оролцогч талуудын оролцоог хангах механизм /Stakeholder engagement/</p>	<p>Энэ сэдэв нь манай оролцогч талуудын хүлээлт, хэрэгцээ, шаардлагыг ойлгож, эрх ашгийг хүндэтгэн үзэх зорилгоор тэдэнтэй харилцах болон санал гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмын тухай байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Оролцогч талуудын оролцооны засаглалын бодлого, журам</li> <li>• Оролцогч талуудтай харилцах төлөвлөгөө</li> <li>• Ажилчид/олон нийтийн санал гомдол</li> <li>• Гишүүнчлэл</li> <li>• Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт</li> </ul>
<p>Санхүүгийн мэдлэг, боловсрол /Financial literacy and education/</p>	<p>Энэ сэдэв нь иргэдийн орон сууцны санхүүжилтийн тогтолцоо болон ипотекийн зээлийн тухай ойлголт, санхүүгийн боловсролын тухай байна. Мөн МИК нь хоёрдогч зах зээлд анхдагчийн хувьд тус зах зээлийн хөгжил, тогтолцоонд оруулж буй хувь нэмэр, know-how болон нөлөөллийн тухай багтаж болно.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Иргэдийн санхүүгийн мэдлэг</li> <li>• Хоёрдогч зах зээлийн хөгжил</li> </ul>

# НИЙГЭМ

Сэдэв	Тодорхойлолт	Дэд сэдэв
<p>Хүмүүн капиталын хөгжил /Human capital development/</p>	<p>Энэ сэдэв нь манай байгууллагын хүмүүн капитал болох ажилтны эрүүл мэнд, боловсрол, мэдлэг чадвар, дадлага туршлага зэргийг хөгжүүлэхэд чиглэсэн хүний нөөц, хөгжлийн бодлого, арга барилын тухай байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалт</li> <li>• Ажилтнуудын тэтгэмжийн хөтөлбөр</li> <li>• Байгууллагын соёл</li> <li>• Шагнал урамшуулал</li> <li>• Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)</li> <li>• Хүний нөөцийн тогтвортой байдал</li> </ul>
<p>Хүн ам зүй, нийгмийн чиг хандлага /Demographic and societal trends/</p>	<p>Энэ сэдэв нь манай санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт, нийлүүлэлт, үнэ зэрэгт нөлөөлөх нийгмийн буюу улсын хүн ам, олон нийтийн насжилт, соёл болон чиг хандлагад хамаарах манай бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийн тухай байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хүн амын өсөлт, насны суварга</li> <li>• Олон нийтийн хандлага</li> </ul>
<p>Эдийн засгийн хувь нэмэр /Economic contribution/</p>	<p>Энэ сэдэв нь манай бизнесийн эдийн засгийн тогтолцоо, дэд бүтэц болон нийгэм олон нийтийг тогтвортой байлгахад оруулж буй хувь нэмэр, бусад салбарт нөлөөлж буй нөлөөллийн тухай байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Барилга, ҮҮХ-ийн салбар</li> <li>• Банк, санхүүгийн салбар</li> <li>• Хөрөнгийн зах зээл</li> <li>• ДНБ</li> <li>• Татвар</li> </ul>

## НИЙГЭМ

Сэдэв	Тодорхойлолт	Дэд сэдэв
<p>Эрх тэгш боломж /Equal opportunity/</p>	<p>Энэ сэдэв нь манай байгууллагын ажил олгох, хөдөлмөр эрхлэх зэрэгтэй холбоотой харилцаанд тэгш бус байдал, гадуурхалтыг бууруулах, эрх тэгш оролцоог хангахад чиглэсэн механизмын тухай байна.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Жендерийн бодлого, журам</li> <li>• Ажилтнуудын хүйсийн харьцаа</li> <li>• Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам</li> <li>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам</li> <li>• Оффисын хүртээмж</li> </ul>

## ЗАСАГЛАЛ

Сэдэв	Тодорхойлолт	Дэд сэдэв
Бизнесийн ёс зүй /Business ethics/	Энэ сэдэв нь бизнесийн ёс зүйтэй холбоотой эрсдэл, боломжийг удирдах компанийн арга барилын тухай байна.	<ul style="list-style-type: none"> <li>Ёс зүйн дүрэм</li> <li>Мэргэжлийн, салбарын, бизнесийн ёс зүй</li> </ul>
Ил тод байдал /Transparency/	Энэ сэдэв нь манай компанийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа болон эрсдэл ба гүйцэтгэлтэй холбоотой оролцогч талууд болон олон нийтэд хүрэх шаардлага бүхий мэдээллийг зохих ёсоор ил тод, үнэн зөв, бүрэн бүтэн тайлагнах механизмын тухай байна.	<ul style="list-style-type: none"> <li>Олон нийтэд ил тод мэдээлэх</li> </ul>
Комплаенс /Compliance/	Энэ сэдэв нь санхүүгийн салбарт мөрдөгдөж буй хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлагыг дагаж мөрдөхтэй холбоотой болон санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалтуудын нийцлийг хангах тухай байна.	<ul style="list-style-type: none"> <li>Комплаенсын бодлого</li> <li>Комплаенсын хөтөлбөр</li> </ul>
Улс төрийн тогтвортой байдал /Political stability/	Энэ сэдэв нь улс төрийн тогтолцооны тогтворгүй, тодорхой бус байдлаас үүдэлтэйгээр бодлого, дүрэм журам, зохицуулалт, шийдвэр гаргалтын өөрчлөлтөөс үүссэн болон үүсэж болзошгүй улс төрийн эрсдэлийг зохистой түвшинд удирдах зорилгоор зохицуулагч байгууллагуудтай харилцах, мэдээллээр хангах, зохих арга аргачлалыг санал болгох зэрэг авч хэрэгжүүлдэг хариу арга хэмжээний тухай байна.	
Хувийн мэдээллийн нууцлал ба өгөгдлийн хамгаалалт /Privacy and data protection/	Энэ сэдэв нь хувь хүний мэдээлэл болон бусад харилцагчийн өгөгдлийг цуглуулах, ашиглах, хамгаалахтай холбоотой тогтолцооны тухай байна. Үүнд мэдээллийн технологийн дэд бүтэц, сургалт, албан хэрэг хөтлөлт, хэрэглэгчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад ашигладаг бусад механизмтай холбоотой компанийн стратеги, бодлого, практикийг тусгана.	<ul style="list-style-type: none"> <li>Мэдээллийн аюулгүй байдал</li> <li>Цахим аюулгүй байдал</li> </ul>

## ЗАСАГЛАЛ

Сэдэв	Тодорхойлолт	Дэд сэдэв
Эрсдэлийн удирдлага /Enterprise risk management/	Энэ сэдэв байгууллагын одоогийн болон зорилтот үйл ажиллагаанд учирч болзошгүй аюул болон эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, тэдгээрийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааны тухай байна.	<ul style="list-style-type: none"><li data-bbox="1126 461 1481 551">• Зах зээлийн эрсдэл</li><li data-bbox="1126 562 1481 651">• Зээлийн эрсдэл</li><li data-bbox="1126 663 1481 779">• Үйл ажиллагааны эрсдэл</li><li data-bbox="1126 790 1481 913">• Харилцагч талын эрсдэл</li></ul>